

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

**Байгаль орчны үнэлгээ, усны  
асуудал хариуцсан мэргэжилтний  
үйл ажиллагааны төлөвлөлт,  
хэрэгжилтэнд хийсэн дотоод хяналт  
шалгалтын тайлан**

2022 он

## АГУУЛГА

- 1.Удирдамж
- 2.Тайлан
- 3.Зөвлөмж

### Байгаль орчны үнэлгээ, усны асуудал хариуцсан мэргэжилтний үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэнд хийсэн дотоод хяналт шалгалтын тайлан

2022.10.13

Байгаль орчин аялал жуулчлалын салбарт хэрэгжиж буй Хог хаягдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт, албан хаагчийн ажлын зохион байгуулалт, ажлын гүйцэтгэлд дотоод хяналт хийх, зөвлөн туслах, илэрсэн зөрчлийг арилгах хүрээнд дотоод хяналт хийсэн.

#### Эрх зүйн үндэслэл:

- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
- Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”

Дотоод хяналтыг Дээрх бодлогын баримт бичиг, төлөвлөгөөний хэрэгжилт тэдгээртэй холбогдуулан гаргасан төлөвлөгөө тайлан, зохион байгуулсан арга хэмжээ, түүний хэрэгжилт, үр дүн зэргийг баримт бичигт тулгуурлан үзэж, дүгнэлт гаргасан болно.

Хамрагдах албан хаагч: Н.Намуунцэцэг Байгаль орчны үнэлгээ, усны асуудал хариуцсан мэргэжилтэн

#### Дотоод хяналт шалгалт хийсэн хугацаа

Хяналт, шалгалтыг 2022 оны 10 сарын 11-13-ны өдрийн хугацаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хүний нөөц, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Гандулам хийж гүйцэтгэсэн.

Дараах үзүүлэлтээр үнэлгээ өгсөн. Мэргэжилтний бичиг баримтанд тулгуурлан үзэж зөвлөмж өгсөн.

№	Нэрс	Албан тушаал	Төлөвлөлт	Бичиг баримтын эмх цэгц		Хууль тшогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтанд авсан байдал	Авсан оноо
				Хууль, журмын хавтас	Судалгаа, мэдээллийн сан		
1	Н.Намуунцэцэг	Байгаль орчны үнэлгээ, усны асуудал хариуцсан мэргэжилтэн	4	3	5	4	16

2022 онд хяналтанд авсан байдал:

№	Албан хаагчийн нэр	ЗДҮАХ-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хяналтанд авсан арга хэмжээний тоо	ЗГҮАХ-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хяналтанд авсан арга хэмжээний тоо	ХТТШБиелэлт Хяналтанд авсан
1	Н.Намуунцэцэг	4	3	1 тогтоол 3 заалт

Төлөвлөлтөнд дараах нийтлэг алдаа байна.

1. Арга хэмжээ болон хугацааг ерөнхий төлөвлөсөн.
2. Бодлогын баримт бичгүүдийн уялдааг сайн хангаагүй.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалын 5 дугаар хавсралт “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын 1.1. “Бодлогын баримт бичиг болон хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ”-г хэрэгжүүлэх зорилгоор тухайн албан хаагч гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг тодорхойлохдоо дараах арга зүйг мөрдлөг болгоно. Үүнд: 1.1.2. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, стратеги төлөвлөгөөнд тусгагдсан ижил нэршилтэй, ижил утгатай, бие биеэ агуулсан утгатай зорилт, арга хэмжээг нэгтгэж, нэг арга хэмжээ болгон тодорхойлох; 1.1.3. Гүйцэтгэлийн зорилт болон зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ хоорондын уялдааг хангах; гэж заасныг баримтлан төлөвлөх шаардлагатай.

Дүгнэх үзүүлэлт	Тайлбар
Төлөвлөлт	Төрийн албан хаагчийн төлөвлөлт дунд. Цаашид сайжруулах шаардлагатай. Хүрээлэн буй орчны бохирдол, байгалийн гамшиг, газрын асуудал хариуцсан мэргэжилтэнтэй уялдаатай ажиллах шаардлагатай.
Тайлагналт	Сарын мэдээний байдалд үнэлэлт өгсөн. Зарим ажлуудыг дутуу тайлагнасан. Үг үсэг, найруулгын алдаатай.
Баримт бичгийн эмх цэгц	Ажлын хавтасуудтай. /Өөртэй холбоотой баримт бичиг./ Мэдээллийн сан үүсгэсэн. /Цаасаар file-аар байгаа/ Байгууллагуудын БОУ-ны төлөвлөгөө тайланг цэгцлэх
Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтанд авсан байдал	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтанд авсан. Өөрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хавтасандаа хийсэн.
Ололттай тал	1. Төрийн албан хаагчийн төлөвлөлт сайн. 2021 он байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд орсон арга хэмжээ, албан хаагчийнхтай давхцсан. Цаашид сайжруулах шаардлагатай.

## Цаашид анхаарах зөвлөмж

### Энэхүү зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 11 сарын 10-нд тайлагнах

1. Бодлогын баримт бичгийн зорилтуудыг хангахад чиглэсэн оновчтой арга хэмжээ төлөвлөх
2. Жилийн эцсийн тайланг шалгуурын дагуу үг үсэг, найруулгын алдаагүй, тоо баримттай, үр дүнг тайлагнахад онцгой анхаарах
3. Сумдын ЗДТГ болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах, ажлын уялдаа холбоог сайжруулах

Ахлах мэргэжилтэн

Б.Гандулам